

***Улаанбаатар хотын тандалтын
нэгжүүдээр дэмжлэгт хяналт
хийсэн ажлын товч тайлан***

Ч.Уртнасан, ТҮН

Дэмжлэгт хяналт хийсэн газрууд

№	Аймаг, дүүргийн нэр	Дэмжлэгт хяналт хийсэн хугацаа	Дэмжлэгт хяналт хийсэн эмчийн нэр
1	Нийслэлийн 8 дүүрэг	11-р сарын 23 12-р сарын 10	Ч.Уртнасан, Т.Оюун-Эрдэнэ, Т.Ууганжаргал, Б.Ганцоож, Г.Нарантуяа, Ч.Баясгалан

Зорилго

Зорилго 1

Үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх, тандалтын явц, аудио хурал хийх бэлэн байдалтай танилцан заавар, зөвлөмж өгөх

Зорилго 2

Мэдээний чанарт хяналт тавин сайжруулах

Зорилго 3

Халдвар хяналтын байдал



Хийж гүйцэтгэсэн ажлууд

- Улаанбаатар хотын харуулдан тандалтын нэгжүүдэд ТТӨ, АЗЦХХ-ын тандалтын үйл ажиллагаанд асуумжын дагуу үнэлгээ хийсэн
- Нэгж бүрд нэг удаагийн маск, сурталчилгааны материалыг тараан өгсөн.
- ТТӨ, АЗЦХХ-ын бүртгэл мэдээллийн үнэн зөв байдлыг эмчийн бүртгэл, мэдээ өгөлтийн бүртгэлтэй тулган үзэн, илэрсэн дутагдал зөрчлийн талаар санал солилцон, шийдвэрлэсэн.
- Томуугийн вэб сайт болон Томуугийн үндэсний төвөөс бэлтгэн гаргадаг эргэн мэдээллийн үйл ажиллагаандаа хэрхэн ашигладаг, цаашид хэрхэн ашиглах талаар мэдээлэл өгсөн.
- Тандалтын нэгжүүдэд skype хаяг нээн микрофон суулгаж өгсөн.
- НАД-ийн Амь-Эрдэнэ ӨЭМТ-ийн эмч, сувилагч нар бүгд шинэчлэгдсэн тул ажлын байранд сургалтыг хийсэн.



Тандалт, хариу арга хэмжээ

ТТӨ-ий үеийн бэлэн байдлын болон Томуугийн цартахлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тогтмол тодотгол хийдэг,
Хариу арга хэмжээг шатлал тус бүрээр төлөвлөн гарган мөрдөн ажиллаж байсан.

Сургалт сурталчилгааны төлөвлөгөө гарган, ард иргэдэд зориулсан санамж, зурагт хуудсыг өөрсдөө боловсруулан гаргасан, ХӨСҮТ, НЭМҮТ-ийн вэб сайтаас татан олшруулан тарааж, сурталчилгаа, мэдээллийн самбарыг ажиллуулдаг,



Эрсдэлт бүлэгт хамрагдах 65 болон түүнээс дээш насны хүмүүс, уушгины архаг өвчтэй, жирэмсэн эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүдийн судалгааг гарган шинэчилсэн,

Томуугийн тандалтын эргэн мэдээллийг эмч, эмнэлгийн ажилчдад 7-14 хоногт 1 удаа мэдээлэл хийн дүгнэлт гаргадаг

ЭМТ-үүдээр НЭМГ-аас долоо хоногт 1 удаа, ӨЭМТ-өөр 14 хоногт 1 удаа ЭМТ-өөс ТТӨ-ний үед хийн хэрэгжүүлж байгаа ажтлд хяналт хийдэг ба нэгж бүр 7 хоног бүр илтгэх хуудас НЭМГ-т хүргүүлдэг байна.



Томуугийн тандалтын мэдээний хувьд

ЭМТ,НЭ

- E-health систем нэвтэрсэн тул программаас шууд аван мэдээлдэг нь J00-J22 хүртэлх код бүрэн хамрагдаж байсан

ӨЭМТ

- Амбулаторийн нийт үзлэгт бүх үзлэгээ авдаг боловч ТТӨ-ийг бүртгэхдээ хэд хэдэн зөрөөтэй байна.
 - Хувийн болон өөр бусад эмнэлэгт (НЭ, ӨЭМТ) үзүүлээд ирсэн болон тухайн эмнэлгийн өөр өөр эмчид үзүүлснээс шалтгаалан зарим тохиолдолд давтан зарим тохиолдолд шинэ гэж авч байна
 - ӨЭМТ-үүд ICD кодоор ялгаатай мэдээлж байсан

Дүүрэг	ӨЭМТ-ийн нэр	ICD код	Тайлбар
БЗД	Амгалан Итгэхүй	J00-J18	
	Насан-Урт	J00-J22	
	Эрүүл өрх	J00-J22	
СХД	Буянт манал	J10, J13, J14, J04	
	Энх Элбэрэл	J03, J06	
	Өнө Ачит	J12	
ЧД	Үйлс нэгтэн	J00-J18	эмчийн 1а маягт дээрх үзлэгийн болон ТТӨ-ий мэдээг тулган үзэхэд зөрүүтэй зөрчлүүд байсан
	Санколл	J00-J06	
	Тэгш мэнд	J00-J06	
ХУД	Амин тус	J00-J06	зөвхөн 0-5 насны хүүхдийн өвчлөлийг авдаг
	Манал Үйлс	J06, J18, J20, J40	
	Энх титэм	J00-J06	
СБД	Тэгш мэнд	J10-J22	
	Санкол	J10-J12	
	Энхсүндэр	J00-J06	
БГД	Гурван санчир	J00-J06	
	Итгэл Угтах	J00-J06	
	Шар дэгд	J00-J06	
НА	Амь-Эрдэнэ	J00-J06	

Халдварын сэргийлэх үйл ажиллагаа НЭ-д:

- Хүлээн авах тасагт хөтөч сувилагч, чимээгүй хөтөчийн тусламжтай шинж тэмдэгээр ялган, ангилах, амьсгалын цочмог халдвартай үйлчлүүлэгчид амны хаалт зүүлгэхгүй байна.
- Цагийн тариа хийхдээ эмчлүүлэгчдийг тарианы өрөөний үүдэнд дугаарлан зогсоож бөөгнөрөл үүсгэхгүй байх.
- Үзлэг, эмчилгээний өрөө бүрт гар арчих нэг удаагийн цаасан алчуур хангалтгүй, спиртэн суурьтай гар халдваргүйтгэгч байгаа боловч үзлэгийн үед үйлчлүүлэгч болгонд хүрэхийн өмнө болон дараа гараа халдваргүйжүүлэхгүй байна.
- Олон туншилтэй тарилгын шингэний задалсан хугацааг тавиагүй, тарилгын шингэнд нэг удаагийн зүүг зоож орхисон, задалсан зүү тариурыг ариутгасан хөвөн бөмбөлөг дотор хадгалсан, ариун хөвөн шарикийг ариун байдлыг алдагдуулан хэрэглэж байна. Тарилгын аюулгүй байдалд анхаарч ажиллах шаардлагатай.
- Нэг удаагаар хэрэглэх зориулалт бүхий утлагын аппаратны хошууг халдваргүйтгэл хийн давтан ашиглаж байна.
- Эмчлүүлэгчийн өрөөнд байгаа агаар чийгшүүлэгчийн ус дууссан. Ус агуулагч савны дотор талын цэвэрлэгээ хангалтгүй байна.

Халдварын сэргийлэх үйл ажиллагаа ӨЭМТ:

- Үзүүлэхээр ирж буй иргэдэд шинж тэмдэгийн ангилан ялгалт хийхгүй, амьсгалын замын халдвар, томуу, томуу төст өвчний улмаас үзүүлэх бол энэ өрөөнд үзүүлнэ үү гэх байдлаар эхний үзлэгийн хэсгээс эхлээд тусгаарлах арга хэмжээ авахгүй байна.
- Өрхийн эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдэд нэг удаагийн амны хаалт зүүлгэхгүй, томуу, томуу төст өвчин их байгаа тул эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх үедээ амны хаалт хэрэглэх талаар иргэдэд зөвлөгөө, санамж анхааруулга өгөхгүй байна.
- ӨЭМТ-дэд хэрэглэж байгаа нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл тоо болон чанарын хувьд шаардага хангахгүй, шүүлтүүртэй амны хаалт байхгүй, нүдний шил нь зориулалтын бус салхины шил байна.
- Ариутгасан материалыг хугацаа хэтрүүлэн хадгалдаг, бүрэн бүтэн байдал битүүмжлэл алдагдсан наалт задарсан хэрэглэж байна.
- Утлага эмчилгээнд хэрэглэгдэж буй эм бэлдмэлийн хадгалалт буруу. Хүүхдэд хэрэглэх утлаганы эмийг хувааж хэрэглэдэг, найруулаад үлдсэн шингэн эмийг ил задгай хадгалсан.
- Утлагын аппаратны нэг удаагаар хэрэглэх маск хангалтгүйгээс халдваргүйжүүлээд давтан хэрэглэдэг.
- Эмнэлгийн аюултай хог хаягдлыг буруу ангилан ялгаж цуглуулж байна.


ДҮГНЭЛТ




- ✓ Энэ томуугийн улиралд ЭМЯ-ны зүгээс албан даалгавар, ТТӨ-ний дэгдэлтийн үед ажиллах төлөвлөгөө гаргасан мөн эдгээрийн хэрэгжилтийг 7 хоног бүр авч байгаа



- ✓ Тандалтын нэгжүүдээр ТТӨ-нөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгаа өргөн хүрээнд хийгдэж байна



- ✓ НЭМГ, дүүргийн ЭМТ-өөс дэмжлэгт хяналтыг тогтмол хийдэг, Засаг захиргааны нэгжтэй хамтран ажилладаг



Тандалтын
нэгжүүдийн үйл
ажиллагаа жигдэрсэн,
хариу арга хэмжээг
хангалттай сайн
идэвхтэй байна.



Тандалтын мэдээг чанаржуулах

- Томуу, томуу төст өвчин (ТТӨ) – сүүлийн 10 хоногт 38⁰С дээш халуурах, ханиалгах шинжээр илрэх амьсгалын замын цочмог халдвар (ICD-10 код- J00-J22)
- Амьсгалын замын цочмог хүнд халдвар (АЗЦХХ) - сүүлийн 10 хоногт 38⁰С дээш халуурах, ханиалгах шинжээр илрэх эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай амьсгалын замын цочмог халдвар (ICD-10 код- J00-J22)
- Нэг хамтлаг, хамт олны дунд 2 ба түүнээс дээш хүнд 10 хоногийн хугацаанд эмнэлзүйн шинж тэмдэг гэнэт илрэхийг “**ГОЛОМТОЛСОН ӨВЧЛӨЛ**” гэж тус тус үзнэ

Сорьцыг тогтмол тасралтгүй чанартай авч, бүртгэлийг сайжруулах

- Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын хүнд халдвар, голомтолсон өвчлөл гэсэн тохиолдлын тодорхойлолтын дагуу оношлосон эмч, эмчилгээ эхлэхээс өмнө өвчний эхний 3 хоногт сорьцыг цуглуулна
- Амьсгалын дутагдалд орсон, АЗЦХХ-ийн шалтгаант нас баралтын тохиолдол бүрээс сорьц авна
- Сорьцыг ХӨСҮТ-д хүргүүлэхээс өмнө FIS программд сорьцын мэдээллийг оруулна.

АНХААРАН
СОНССОНД
БАЯРЛАЛАА

